

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/138/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дорноговь аймаг

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020

Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Утас: 70523020

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ДГА	Дорноговь аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	12
3.1	Удирдлагын дээд болон дотоод хяналт .....	12
3.1.1	Илрүүлэлт:.....	12
3.1.2	Эрсдэл: .....	12
3.1.3	Өгсөн зөвлөмж: .....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	20
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	21

## 1 Аудитын гэрчилгээ

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 2019.02.25 № 1-6/157 Таний _____ -ны № _____ -г	<b>ДОРНОГОВЬ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ДАРГА С.ЦЭРЭНСАМБУУ ТАНАА</b>
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Прокурорын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Сөрөг санал дүгнэлт</b>	
<p>Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Дорноговь аймгийн Прокурорын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Прокурорын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

### Аудитын гол асуудал

Нягтлан бодогчоор ажиллаж байсан Ч.Туул нь 2018 оны 1, 2, 3, 4 саруудад Хаан банк, Голомт банк, Капитрон банкинд өгөх жагсаалтыг засч байгууллагын ажилчдын нэр дээр илүү дүнгээр өөрийн дансанд 8.5 сая төгрөгийг цалингийн сангаас гаргаж авсан байна. Ч.Туул нь үүнээс 0.8 сая төгрөгийг эргэн төлж, 2018 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайланд 7.7 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Харилцахаас анхан шатны баримт буюу нэхэмжлэх, зарлагын баримтгүйгээр 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр О.Түмэн-Өлзийгийн дансанд 1.2 сая төгрөг, 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Альянс трейд ХХК руу 3.8 сая төгрөгийг шилжүүлж тухайн байгууллагаас бэлэн мөнгөөр гарган авсан байна. Уг мөнгийг Ч.Туулаар эргэн төлүүлж бараа материал худалдан авсан байна.

Эдгээр зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн толилуулга ба илчлэл үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаагаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Прокурорын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг аймгийн Прокурорын газарт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Прокурорын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 15-аас 2019 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Прокурорын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 2/158 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Прокурорын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Прокурорын газар нь Хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөө, нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Прокурорын тухай хуулиар Дорноговь аймгийн Прокурорын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага.

Дорноговь аймгийн Прокурорын газар үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Прокурорын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Прокурорын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд “Дунд” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах “шаардлагагүй” гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Прокурорын газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acoulous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Прокурорын газар дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Прокурорын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр -ын хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийгдсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2018 оны Нийт зардал 455,953.2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 4,559.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	125.2	Албан томилолтын үнэмлэхний ажилласан газар, ирсэн явсан огноогүй. Мөн албан хаагчид томилолтоор ажиллахдаа гүйцэтгэх ажлын удирдамжгүй, гүйцэтгэсэн ажлын тайлан бичдэггүй байна.
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	1	125.2	

**2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

**2.8.1.1 Илрүүлэлт. Балансын данстай холбоотой асуудал**

Санхүүгийн байдлын тайлангийн түлш шатах тослох материал 770.0 мянган төгрөг, бараа материалын тайлангийн түлш шатах тослох материалын эцсийн үлдэгдэл 750.0 мянган төгрөг буюу 20.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу цаг хугацаанд нь, үнэн зөв . . . бүртгэж тайлагнах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Эрсдэл.** Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

**Шийдвэрлэсэн:** Аудитын явцад залруулах.

## **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Прокурорын газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, 3 арга хэмжээнд зориулан 2018 онд 455,953.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 455,737.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Прокурорын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьтай байна.

Анхан шатны баримтыг бүрдүүлэх, архивлах ажлыг сайжруулах гэсэн зөвлөмж хэрэгжээгүй байна. Учир нь даргын гарын үсэг, тамгагүй, төрийн сангийн тэмдэггүй 6 ширхэг 2.4 сая төгрөгийн төлбөрийн хүсэлтийг /2018.02-04 сарын хоорондох/ харилцахын баримтад архивласан. Төлбөрийн хүсэлтүүдийг гарын үсэг, тамга тэмдэгтэй болгохыг нягтлан бодогчид хариуцуулав.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Прокурорын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Удирдлагын дээд болон дотоод хяналт**

**3.1.1 Илрүүлэлт.** Томилолт бодож олгохдоо албан томилолтын үнэмлэхний ажилласан газар, ирсэн явсан огноогүй 125.2 мянган төгрөгийн томилолт олгосон. Мөн албан хаагчид томилолтоор ажиллахдаа гүйцэтгэх ажлын удирдамжгүй, гүйцэтгэсэн ажлын тайлан бичдэггүй байна.

Энэ нь Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 3 дахь заалттай нийцэхгүй байна.

**3.1.2 Эрсдэл.** Тооцоолол буруу хийгдэж илүү, дутуу томилолт олгогдох.

**3.1.3 Өгсөн зөвлөмж.** Томилолт олгохдоо Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

---

- 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,772,244.22</b>	<b>21,769,608.42</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,632,390.00	7,794,080.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	7,794,080.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,632,390.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	1,632,390.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	10,139,854.22	13,975,528.42
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,139,854.22	13,975,528.42
35410	Бичиг хэргийн материал	1,025,700.00	1,892,700.00
35420	Аж ахуйн материал	5,789,715.00	8,403,448.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,922,360.00	1,922,360.00
35440	Түлш, шатах тослох материал	590,079.22	750,020.42
35470	Бусад хангамжийн материал	812,000.00	1,007,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>426,919,963.46</b>	<b>343,143,025.34</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	426,919,963.46	343,143,025.34
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	426,919,963.46	324,071,025.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	470,571,700.00	297,784,630.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-63,802,067.68	-2,394,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,900,000.00	67,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-67,900,000.00	-67,900,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,612,414.00	33,930,718.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,378,780.45	-23,022,385.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,390,678.00	40,414,466.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,073,263.24	-23,149,185.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	925,000.00	925,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-325,717.17	-418,217.13
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	19,072,000.00
39301	Програм хангамж	917,500.00	917,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-917,500.00	-917,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	19,072,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>438,692,207.68</b>	<b>364,912,633.76</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>438,692,207.68</b>	<b>364,912,633.76</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	438,692,207.68	364,912,633.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	311,381,920.10	330,453,920.10
51101	Өмч: - төрийн	311,381,920.10	330,453,920.10
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	32,466,347.03	-77,399,158.64
51210	Өмнөх үеийн үр дүн	32,466,347.03	32,466,347.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-109,865,505.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,843,940.55	111,857,872.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>438,692,207.68</b>	<b>364,912,633.76</b>

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>442,652,000.00</b>	<b>467,991,604.13</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,000,000.00</b>	<b>8,538,404.13</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,000,000.00	8,538,404.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,000.00	8,538,404.13
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,000,000.00	8,538,404.13
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>439,652,000.00</b>	<b>459,453,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	434,152,000.00	455,953,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	434,152,000.00	455,953,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,000,000.00	3,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	3,500,000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	1,500,000.00	00.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	1,500,000.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>468,249,585.94</b>	<b>456,979,874.15</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>468,249,585.94</b>	<b>456,979,874.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	465,138,044.94	456,763,884.15
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	362,761,429.00	360,340,089.00
210101	Үндсэн цалин	358,027,429.00	206,928,761.00
210102	Нэмэгдэл	00.00	148,447,478.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,734,000.00	4,963,850.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,343,663.00	43,268,900.00
210201	Тэтгэврийн даатгал	26,969,663.00	29,275,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,221,000.00	3,498,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,669,500.00	2,798,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	549,500.00	699,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,934,000.00	6,996,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,317,297.00	14,190,004.00
210301	Гэрэл, цахилгаан	1,834,419.00	1,895,295.00
210302	Түлш, халаалт	10,942,322.00	8,161,134.00
210303	Цэвэр, бохир ус	1,540,556.00	4,133,575.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,474,907.20	16,377,832.80
210401	Бичиг хэрэг	4,886,309.00	4,639,679.00
210402	Тээвэр, шатахуун	3,949,618.20	5,528,848.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,741,149.00	3,403,585.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,407,371.00	2,296,520.00
210408	Бараа материал акталсны зардал	250,460.00	269,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	18,250.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,250.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,502,000.00	3,782,210.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,902,000.00	3,782,210.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,496,000.00	1,624,400.00
210702	Дотоод албан томилолт	1,496,000.00	1,624,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	148,800.00	2,547,230.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,175,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	230,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,800.00	101,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210807	Газрын төлбөр	44,000.00	18,430.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	34,075,698.74	14,633,218.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,660,505.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	304,000.00	730,000.00

Дорноговь аймаг дахь Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,111,193.74	13,903,218.35
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,111,541.00	215,990.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,064,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,064,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	47,541.00	215,990.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,541.00	215,990.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-25,597,585.94</b>	<b>11,011,729.98</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	372,260.00	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	372,260.00	00.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	75,992.50	120,877,235.65
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	75,992.50	287,263.18
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	120,589,972.47
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	296,267.50	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-25,301,318.44</b>	<b>109,865,505.67</b>

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>441,476,414.00</b>	<b>459,453,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>44,493.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	44,493.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,493.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,493.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>441,431,921.00</b>	<b>459,453,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	434,152,000.00	455,953,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	434,152,000.00	455,953,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,000,000.00	3,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	3,500,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	3,279,921.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,279,921.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>437,256,414.00</b>	<b>452,879,020.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>437,256,414.00</b>	<b>452,879,020.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>434,144,873.00</b>	<b>452,663,030.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	359,354,901.00	368,808,215.00
210101	Үндсэн цалин	306,918,876.00	211,419,739.00
210102	Нэмэгдэл	35,228,664.00	145,334,125.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,770,806.00	12,054,351.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,436,555.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,428,200.00	43,268,900.00
210201	Тэтгэврийн даатгал	39,428,200.00	29,275,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,498,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,798,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	699,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	6,996,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,440,000.00	14,180,554.00
210301	Гэрэл, цахилгаан	1,834,419.00	1,895,295.00
210302	Түлш, халаалт	11,731,291.00	9,767,035.00
210303	Цэвэр, бохир ус	4,874,290.00	2,518,224.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,140,000.00	16,095,708.00
210401	Бичиг хэрэг	3,646,483.00	4,785,893.00
210402	Тээвэр, шатахуун	4,527,132.00	4,065,850.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	2,012,150.00	3,526,765.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	714,235.00	3,477,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	50,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	800,000.00	4,514,303.00
210604	Урсгал засвар	800,000.00	4,514,303.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,440,000.00	1,624,400.00
210702	Дотоод албан томилолт	1,440,000.00	1,624,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	314,800.00	3,170,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	2,798,720.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	230,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,800.00	101,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,000.00	00.00
210807	Газрын төлбөр	22,000.00	18,430.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,176,972.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,778,972.00	00.00

Дорноговь аймаг дахь Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	398,000.00	1,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,111,541.00</b>	<b>215,990.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,064,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,064,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	47,541.00	215,990.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,541.00	215,990.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>4,220,000.00</u></b>	<b><u>6,574,180.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>4,220,000.00</b>	<b>6,574,180.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,220,000.00</b>	<b>6,574,180.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	4,220,000.00	6,574,180.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,220,000.00	6,574,180.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-4,220,000.00</u></b>	<b><u>-6,574,180.00</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

Дорноговь аймаг дахь Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

СТ-4А

**АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	311,381,920.10	94,843,940.55	54,832,828.97	461,058,689.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,858,844.00	2,858,844.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>311,381,920.10</b>	<b>94,843,940.55</b>	<b>57,691,672.97</b>	<b>463,917,533.62</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,301,318.44	-25,301,318.44
C08	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>311,381,920.10</b>	<b>94,843,940.55</b>	<b>32,466,347.03</b>	<b>438,692,207.68</b>
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>311,381,920.10</b>	<b>94,843,940.55</b>	<b>32,466,347.03</b>	<b>438,692,207.68</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>311,381,920.10</b>	<b>94,843,940.55</b>	<b>32,466,347.03</b>	<b>438,692,207.68</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	17,013,931.75	00.00	17,013,931.75
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	19,072,000.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-109,865,505.67	-90,793,505.67
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>330,453,920.10</b>	<b>111,857,872.30</b>	<b>-77,399,158.64</b>	<b>364,912,633.76</b>

Дорноговь аймаг дахь Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ТГ

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	455,953,200.00	455,737,210.00	215,990.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	455,953,200.00	455,737,210.00	215,990.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	455,953,200.00	455,737,210.00	215,990.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	368,952,400.00	368,808,215.00	144,185.00
210101	Үндсэн цалин	211,584,000.00	211,419,739.00	164,261.00
210102	Нэмэгдэл	145,242,000.00	145,334,125.00	-92,125.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,126,400.00	12,054,351.00	72,049.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,268,900.00	43,268,900.00	00.00
210201	Тэтгэврийн даатгал	29,275,000.00	29,275,000.00	00.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,498,500.00	3,498,500.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,798,800.00	2,798,800.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	699,700.00	699,700.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,996,900.00	6,996,900.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,181,100.00	14,180,554.00	546.00
210301	Гэрэл, цахилгаан	2,040,000.00	1,895,295.00	144,705.00
210302	Түлш, халаалт	9,266,800.00	9,767,035.00	-500,235.00
210303	Цэвэр, бохир ус	2,874,300.00	2,518,224.00	356,076.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,466,000.00	16,465,608.00	392.00
210401	Бичиг хэрэг	7,209,000.00	5,155,793.00	2,053,207.00
210402	Тээвэр, шатахуун	4,150,000.00	4,065,850.00	84,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,150,000.00	3,526,765.00	-376,765.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	00.00	45,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,672,000.00	3,477,200.00	-1,805,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,449,000.00	6,404,303.00	44,697.00
210604	Урсгал засвар	6,449,000.00	6,404,303.00	44,697.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,640,000.00	1,624,400.00	15,600.00
210702	Дотоод албан томилолт	1,640,000.00	1,624,400.00	15,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,995,800.00	3,985,230.00	10,570.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,620,000.00	3,613,000.00	7,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	230,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,800.00	101,800.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	22,000.00	18,430.00	3,570.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1000000.00	1000000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	00.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	455,953,200.00	455,737,210.00	215,990.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	455,953,200.00	455,737,210.00	215,990.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	455,953,200.00	455,737,210.00	215,990.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	00.00	00.00	0.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	00.00	00.00	0.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	20.00	20.00	0.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	0.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	00.00	00.00	0.00
<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	00.00	00.00	0.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>20.00</b>	<b>20.00</b>	<b>0.00</b>
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	08.00	08.00	0.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	03.00	03.00	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	09.00	09.00	0.00

НТ-2

Дорноговь аймаг дахь Прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,500,000.00</b>	<b>3,500,000.00</b>	<b>0.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,500,000.00	3,500,000.00	0.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,500,000.00	3,500,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,500,000.00	3,500,000.00	0.00
210602	Тавилга	3,500,000.00	3,500,000.00	0.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,500,000.00</b>	<b>3,500,000.00</b>	<b>0.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,500,000.00	3,500,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	3,500,000.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			